



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/671

Булган сум

Усны түвшин хэмжигч автомат төхөөрөмжийг
суурилуулах ажлын зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны ээлжит X хуралдааны Х/74 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор усны түвшин хэмжигч автомат төхөөрөмжийг Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрэн байгууламжид суурилуулах ажлын зардал 1,808,720 (нэг сая найман зуун найман мянга долоон зуун хорь) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 22-ний өдрийн
А/621 дугаар захирамжийн хавсралт

Усны түвшин хэмжигч автомат төхөөрөмжийг гүүрэн
байгууламжид суурилуулах зардлын тооцоо

д/д	Агуулга	Багажийн нэр	Тоо ширхэг, үнэ	Үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Шаардлагатай багаж	Кран	1	1,500,000	2 өдрийн түрээс
2		Мотор	1	120,000	
3		Бетоны цавуу	1	28,000	Худалдаж авна.
4		Ангарын боолт	6	9,000	
5		Сим карт	1	13,000	Автомат станцад суурилуулна.
6	Шатахуун (литр)	Нилух (Авто машин)	51	$51 \times 2720 = 138720$	
Нийт зардал				1,808,720	